ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: АХГ-2022/223/НА-СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

**Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг**
**Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn**
**Аудитын менежер: Б.Сэржмядаг**
**Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn**
**Ахлах аудитор: Б.Нарангэрэл**
**Утас: 261628 Цахим хаяг: narangerelb@audit.gov.mn**
**Аудитор: Ч.Дашдаваа**
**Утас: 261628 Цахим хаяг: dashdavaach@audit.gov.mn**

Улаанбаатар хот
2022 он

**Агуулга**


1. Аудитын санал дүгнэлт ....................3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....................5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....................5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....................6

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....................7

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....................8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................10

3. Аудитын тайлан ....................12

3.1 Ерөнхий зүйл ....................12

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....................12

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....................13

3.4 Материаллаг байдал ....................13

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....................13

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....................14

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....................14

3.8 Аудитын гол асуудал ....................15

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................15

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....................15

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....................15

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....................15

4. Аудитын илрүүлэлт ....................16

4.1 Албан шаардлага ....................16

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....................16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БНСУ | Бүгд найрамдах солонгос улс |
| ЗГ | Засгийн газар |
| ХНХҮТ | Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төв |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/416

танай ______________-ны № ______________-т

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА Д.БАЯРМАНДАХ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9006109
9019120396

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2022\0225 Auditiin 2 Gazar - 69.Docx

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **408,894,096.10** | **378,219,621.10** |
| **33** | **АВЛАГА** | **394,500,000.00** | **360,000,000.00** |
| **33500** | **Бусад авлага** | **394,500,000.00** | **360,000,000.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 131,500,000.00 | 120,000,000.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 263,000,000.00 | 240,000,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **14,394,096.10** | **18,219,621.10** |
| **35400** | **Хангамжийн материал** | **14,394,096.10** | **18,219,621.10** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 261,780.00 | 345,980.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 552,902.00 | 984,062.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 7,544,460.00 | 9,368,460.00 |
| 35460 | Хүнсний материал | 0 | 72,300.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 6,034,954.10 | 7,448,819.10 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **57,521,372.67** | **32,552,339.97** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **57,521,372.67** | **32,552,339.97** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **57,521,372.67** | **32,552,339.97** |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 149,111,940.16 | 149,111,940.16 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (130,161,974.13) | (141,169,313.54) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 53,288,995.40 | 54,080,995.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (24,419,223.80) | (35,744,281.05) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 34,286,364.11 | 34,286,364.11 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (24,584,729.07) | (28,013,365.11) |
| 39301 | Програм хангамж | 770,000.00 | 770,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (770,000.00) | (770,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **466,415,468.77** | **410,771,961.07** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **466,415,468.77** | **410,771,961.07** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **466,415,468.77** | **410,771,961.07** |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **466,415,468.77** | **410,771,961.07** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 426,095,685.22 | 466,415,468.77 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 40,319,783.55 | (55,643,507.70) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **466,415,468.77** | **410,771,961.07** |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| КОД | ҮЗҮҮЛЭЛТ | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,195,767,361.48** | **1,202,796,356.46** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **25,460,861.48** | **32,256.46** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **25,460,861.48** | **32,256.46** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **35,241.48** | **32,256.46** |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 35,241.48 | 32,256.46 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 25,425,620.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,170,306,500.00** | **1,202,764,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,170,306,500.00** | **1,202,764,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,170,306,500.00 | 1,202,764,100.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,192,792,831.40** | **1,223,939,864.16** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,192,792,831.40** | **1,223,939,864.16** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,190,399,198.08** | **1,206,630,685.06** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **875,148,405.51** | **878,634,173.70** |
| 210101 | Үндсэн цалин | 55,963,600.00 | 66,963,700.00 |
| 210102 | Нэмэгдэл | 697,720,205.51 | 677,705,873.70 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 121,464,600.00 | 133,964,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **19,904,605.64** | **19,743,708.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,938,935.53 | 13,863,010.85 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,465,850.07 | 1,539,210.60 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,257,129.32 | 1,214,568.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 294,790.08 | 284,265.29 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,947,900.64 | 2,842,652.87 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **167,499,000.00** | **173,388,900.00** |
| 210302 | Түлш, халаалт | 18,823,800.00 | 12,513,700.00 |
| 210304 | Байрны түрээс | 148,675,200.00 | 160,875,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **42,993,361.38** | **44,455,814.20** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,349,297.20 | 4,505,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,794,179.90 | 13,326,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 16,339,000.00 | 24,976,239.20 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 604,100.00 | 394,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,906,784.28 | 1,253,775.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,266,900.00** | **6,202,800.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 18,900.00 | 4,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,248,000.00 | 6,198,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,244,700.00** | **995,800.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,244,700.00 | 995,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **49,340,800.00** | **53,093,956.46** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,858,600.00 | 10,381,300.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 33,036,800.00 | 34,958,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,137,000.00 | 2,897,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 741,100.00 | 866,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,467,700.00 | 1,272,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 3,099,600.00 | 2,718,056.46 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **29,001,425.55** | **30,115,532.70** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,943,100.00 | 4,354,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 24,058,325.55 | 25,761,032.70 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,393,633.32** | **17,309,179.10** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,393,700.00** | **1,115,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,393,700.00 | 1,115,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **999,933.32** | **16,194,179.10** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 999,933.32 | 16,194,179.10 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **2,974,530.08** | **(21,143,507.70)** |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **39,038,541.71** | **-** |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 39,038,541.71 | - |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **1,693,288.24** | **34,500,000.00** |
| 225004 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | 1,693,288.24 | 34,500,000.00 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **40,319,783.55** | **(55,643,507.70)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **426,095,685.22** | **426,095,685.22** |
| **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **-** | **-** | **-** | **-** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **426,095,685.22** | **426,095,685.22** |
| **Тайлант үеийн үр дүн** | **-** | **-** | **40,319,783.55** | **40,319,783.55** |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **466,415,468.77** | **466,415,468.77** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **466,415,468.77** | **466,415,468.77** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (55,643,507.70) | (55,643,507.70) |
| **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **-** | **-** | **410,771,961.07** | **410,771,961.07** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(төгрөгөөр/)*

| КОД | ҮЗҮҮЛЭЛТ | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,172,244,770.90** | **1,202,796,356.46** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,938,270.90** | **32,256.46** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,938,270.90** | **32,256.46** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **1,938,270.90** | **32,256.46** |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,938,270.90 | 32,256.46 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,170,306,500.00** | **1,202,764,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,170,306,500.00** | **1,202,764,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,170,306,500.00 | 1,202,764,100.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,170,585,770.90** | **1,202,004,356.46** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,170,585,770.90** | **1,202,004,356.46** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,168,192,137.58** | **1,184,695,177.36** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **875,144,152.04** | **878,634,173.70** |
| 210101 | Үндсэн цалин | 55,963,600.00 | 66,963,700.00 |
| 210102 | Нэмэгдэл | 697,715,952.04 | 677,705,873.70 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 121,464,600.00 | 133,964,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **19,904,605.64** | **19,743,708.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,904,605.64 | 10,349,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0 | 2,256,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0 | 3,386,908.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0 | 1,651,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 0 | 2,100,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **167,499,000.00** | **173,388,900.00** |
| 210302 | Түлш, халаалт | 18,823,800.00 | 12,513,700.00 |
| 210304 | Байрны түрээс | 148,675,200.00 | 160,875,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **43,872,279.90** | **48,281,339.20** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,399,000.00 | 4,589,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,794,179.90 | 13,326,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 16,339,000.00 | 24,976,239.20 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 604,100.00 | 513,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,736,000.00 | 4,875,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,243,500.00** | **6,202,800.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 995,500.00 | 4,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,248,000.00 | 6,198,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,244,700.00** | **995,800.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,244,700.00 | 995,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **49,340,800.00** | **53,093,956.46** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,858,600.00 | 10,381,300.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 33,036,800.00 | 34,958,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,137,000.00 | 2,897,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 741,100.00 | 866,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,467,700.00 | 1,272,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 3,099,600.00 | 2,718,056.46 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,943,100.00** | **4,354,500.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,943,100.00 | 4,354,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,393,633.32** | **17,309,179.10** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,393,700.00** | **1,115,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,393,700.00 | 1,115,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **999,933.32** | **16,194,179.10** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 999,933.32 | 16,194,179.10 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **1,659,000.00** | **792,000.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **0** | **792,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0** | **792,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **0** | **792,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 0 | 792,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **0** | **(792,000.00)** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **(1,659,000.00)** | **0** |
| **14** | **Бусад эх үүсвэр** | **34,288.25** | **0** |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 34,288.25 | 0 |
| **25** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | **1,693,288.25** | **0** |
| 250001 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | 1,693,288.25 | 0 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **0** | **0** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 0 |
| 100 | Тохируулгын орлого, зарлагын зөрүү | 0 | 0 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(төгрөгөөр)*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,202,764,100.00** | **1,186,602,177.36** | **16,161,922.64** | 98.7 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,202,764,100.00** | **1,186,602,177.36** | **16,161,922.64** | 98.7 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,201,649,100.00** | **1,185,487,177.36** | **16,161,922.64** | 98.7 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **878,644,300.00** | **878,634,173.70** | **10,126.30** | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 66,963,700.00 | 66,963,700.00 | 0.00 | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 677,716,000.00 | 677,705,873.70 | 10,126.30 | 100.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 133,964,600.00 | 133,964,600.00 | 0.00 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **20,062,000.00** | **19,743,708.00** | **318,292.00** | 98.4 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,349,100.00 | 10,349,100.00 | 0.00 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,256,400.00 | 2,256,400.00 | 0.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,705,200.00 | 3,386,908.00 | 318,292.00 | 91.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,651,300.00 | 1,651,300.00 | 0.00 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,100,000.00 | 2,100,000.00 | 0.00 | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **177,189,200.00** | **173,388,900.00** | **3,800,300.00** | 97.9 |
| 210302 | Түлш, халаалт | 16,314,000.00 | 12,513,700.00 | 3,800,300.00 | 76.7 |
| 210304 | Байрны түрээс | 160,875,200.00 | 160,875,200.00 | 0.00 | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **54,518,300.00** | **48,281,339.20** | **6,236,960.80** | 88.6 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,589,200.00 | 4,589,200.00 | 0.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,326,800.00 | 13,326,800.00 | 4,000,000.00 | 76.9 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 27,213,200.00 | 24,976,239.20 | 2,236,960.80 | 91.8 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 513,500.00 | 513,500.00 | 0.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,875,600.00 | 4,875,600.00 | 0.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,994,800.00** | **6,994,800.00** | **0.00** | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 796,400.00 | 796,400.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 6,198,400.00 | 6,198,400.00 | 0.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **995,800.00** | **995,800.00** | **0.00** | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 995,800.00 | 995,800.00 | 0.00 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **58,890,200.00** | **53,093,956.46** | **5,796,243.54** | 90.2 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,381,300.00 | 10,381,300.00 | 0.00 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 38,235,800.00 | 34,958,800.00 | 3,277,000.00 | 91.4 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 4,252,200.00 | 2,897,200.00 | 1,355,000.00 | 68.1 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 866,600.00 | 866,600.00 | 0.00 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,272,000.00 | 1,272,000.00 | 0.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 3,882,300.00 | 2,718,056.46 | 1,164,243.54 | 70.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,354,500.00** | **4,354,500.00** | **0.00** | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,354,500.00 | 4,354,500.00 | 0.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,115,000.00** | **1,115,000.00** | **0.00** | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,115,000.00** | **1,115,000.00** | **0.00** | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,115,000.00 | 1,115,000.00 | 0.00 | 100.0 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,202,764,100.00** | **1,186,602,177.36** | **16,161,922.64** | 98.7 |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,202,764,100.00** | **1,186,569,920.90** | **16,194,179.10** | 98.7 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,202,764,100.00 | 1,186,569,920.90 | 16,194,179.10 | 98.7 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **0** | **32,256.46** | **(32,256.46)** | |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0 | 32,256.46 | (32,256.46) | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **13** | **13** | **0.00** | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **0.00** | |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 0.00 | |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **6** | **6** | **0.00** | |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 5 | 5 | 0.00 | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **6** | **6** | **0.00** | |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 2 | 2 | 0.00 | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 4 | 4 | 0.00 | |

## 3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу БНСУ-ын Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 23-ны хооронд Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газрын Ахлах аудитор Б.Нарангэрэл, аудитор Ч.Дашдаваа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Сэржмядаг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

БНСУ-ын Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

БНСУ-ын Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирсэн залуусын амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаанд байнгын анхаарал тавьж, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм зааврыг баримтлаагүйгээс осол гэмтэлд орох, тахир дутуу болох, эрдэнэт хүний амь нас эрсдэх нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулж байгаа ХНХЯ-ны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тус төвийн зорилго нь БНСУ-д оршин сууж буй Монгол Улсын иргэдэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхлэх асуудлын хүрээнд хоёр улсын холбогдох хуулийн дагуу хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлыг шийдвэрлэн, нийгмийн даатгалын үйлчилгээг хүртээмжтэй, чанартай үзүүлж, монгол хүний хөгжлийг ахисан түвшинд хүргэх, иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад төрийн үйлчилгээг шуурхай, үр дүнтэй үзүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас Ковид-19 цар тахлын улмаас санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

БНСУ-ын Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-т заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,192,792.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 11,927.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

БНСУ-ын Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,319.8 мянган төгрөгөөр буюу 9.5 хувиар өсөж, материаллаг өөрчлөлт гарсан авлага, хуримтлагдсан үр дүн данснууд байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 394,500.0 | 360,000.0 | (34,500.0) |
| Бараа материал | 14,394.1 | 18,219.6 | 3,825.5 |
| Үндсэн хөрөнгө | 57,521.4 | 32,552.3 | (24,969.1) |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **466,415.5** | **410,771.9** | **(55,643.6)** |
| Засгийн газрын хувь оролцоо | 466,415.5 | 410,771.9 | (55,643.6) |
| Хуримтлагдсан үр дүн | 466,415.5 | 410,771.9 | (55,643.6) |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **466,415.5** | **410,771.9** | **(55,643.6)** |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын данс оны эхний үлдэгдэл 394,500.0 мянган төгрөг, тайлант онд 46,107.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, 80,607.3 төгрөг төлөгдөж эцсийн үлдэгдэл 360,000.0 мянган төгрөг байгаа нь байрны барьцааны авлагууд байна.
- Үндсэн хөрөнгө өмнөх оноос буурсан нь тайлант онд 25,761.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,607,914.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,607,914.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс цалин, НДШ-ийн зардлыг 155,892.3 мянган, Хангамж бараа материалын зардлыг 26,120.0 мянган, томилолт, зочны зардлыг 22,443.8 мянган зэргээр нийт 405,150.5 мянган төгрөгөөр бууруулж 1,186,602.2 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,202,764.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 32.3 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос нийт 1,202,796.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,202,764.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 1,186,602.2 мянган төгрөгийг зарцуулж, 16,194.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,186,602.2 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой зардлыг 328.4 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 6,236.9 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 3,800.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 5,796.2 мянган төгрөгөө дутуу зарцуулснаас голлон шалтгаалсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөг/

| № | Хөтөлбөр, арга хэмжээний | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| 1 | 71902 | Нийгмийн халамж | 1,202,764.1 | 1,186,602.2 | 16,161.9 | 98.7 |
| 1.1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,198,094.5 | 1,181,932.6 | 16,161.9 | 98.7 |
| 1.2 | 80205 | Мэдээлэл, сурталчилгааны зардал | 2,230.0 | 2,230.0 | 0.0 | 100.0 |
| 1.3 | 80218 | Улс орноо гадаадад сурталчлах | 1,324.6 | 1,324.6 | 0.0 | 100.0 |
| 1.4 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 1,115.0 | 1,115.0 | 0.0 | 100.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд БНСУ-ын Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн биелэлтийн хувь 98.7 хувьтай байна.

Тайлант онд хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал болон хөрөнгийн зардалд нийт 1,202,764.1 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,186,602.2 мянган төгрөг зарцуулж 98.7 хувийн биелэлттэй байна.

Хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийн биелэлт түүнийг хэрэгжүүлэхээр баталсан төсвийн гүйцэтгэлийн биелэлт 1.3 хувиар зөрүүтэй буюу төсвийг хэмнэлттэй зарцуулж байгууллагын хүрэх үр дүнд хүрч ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд анхаарал татсан асуудал гараагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

БНСУ-ын Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь ажил гүйлгээ хийх, санхүүгийн тайлан баланс гаргахдаа гадаад валютаас монгол төгрөгт шилжүүлэн тайлагнадаг тул тухайн өдрийн монгол банкны ханшаар хөрвүүлэн бүртгэсэн эсэх, валют хөрвүүлсний олз, гарзыг хүлээн зөвшөөрч бүртгэдэг эсэхийг тулган шалгах.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус төв нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 119 мэдээлэл оруулахаас 118 мэдээллийг хугацаандаа мэдээлж 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

> <u>Шийдвэрлэсэн нь:</u> Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд нь тогтмол оруулж байх, Зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор” заалттай нийцэхгүй байна.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар түүвэрт хамрагдан шалгагдаж акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

БНСУ-ын Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын хугацаанд анхан шатны баримт ирүүлээгүй, тулган баталгаажуулалт хийх боломжгүй тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,880.0 мянган төгрөгийн 1 алдаа зөрчил илэрч албан шаардлага хүргүүлсэн.

Залруулагдаагүй 1 алдаа, зөрчлийн дүн 9,880.0 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 11,927.9 мянган төгрөгөөс хэтрээгүй тул “Зөрчилгүй дүгнэлт” өглөө.

4.1 Албан шаардлага

Байгууллагын албан хаагчдад 11-12 сард нийт 9,880.0 мянган төгрөгийн шагнал урамшууллыг хавтгайруулан олгосон.

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 1-д "Онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна", 1.4-д "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

> Шийдвэрлэсэн нь: Байгууллагын ажилтнуудад шагнал урамшууллыг хавтгайруулан олгохгүй байх, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж амжилттай ажилласан ажилтныг шагнаж урамшуулж байх, Албан шаардлага хүргүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | дүн | Тоо | Дүн | Тоо | дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | БНСУ-ын ХНХҮТөв | АХГ-2022 /223/НА-СТА-ТШЗ | Байгууллагын албан хаагчдад 11-12 сард нийт 9,880.0 мянган төгрөгийн шагнал урамшууллыг хавтгайруулан олгосон байна. | Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн, үнэн зөв бэлтгэн гаргах | 1 | 9,880.0 | | | | | 1 | 9880.0 | | | | |
| 2 | БНСУ-ын ХНХҮТөв | АХГ-2022 /223/НА-СТА-ТШЗ | Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа. БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төв тайлант онд 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. | Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол шуурхай оруулж байх | 1 | | | | | | | | | | 1 | |
| Дүн | | | | | 2 | 9,880.0 | 0 | - | 0 | 0 | 1 | 9,880.0 | - | - | 1 | - |

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 94/А0170064 Улаанбаатар хот

АХЭ-2022/223/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын албан хаагчдад 11-12 сард нийт 9,880,000.00 төгрөгийн шагнал урамшууллыг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 "Онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна", 1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дарга Д.Баярмандах, Санхүү, нягтлан бодох, тоо бүртгэл хариуцсан мэргэжилтэн Я.Гармаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Б.СЭРЖМЯДАГ
АУДИТОР Ч.ДАШДАВАА

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-93.Docx

0010800301

ТЭМДЭГЛЭЛ

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................